

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



Шавь хүний амьдрал

30 жилийн өмнө Гана улсын нэгэн коллежийн оюутан Доу анх удаа ХҮГ цуглааны байранд хөл тавьжээ. Найз нь Доуг хамт явъя хэмээн урьсан бөгөөд түүнд Сүм ямар байхыг мэдэх хүсэл төрсөн байв.

Тэнд байсан хүмүүс эелдэг, сайхан ааш зантай байсан бөгөөд түүнд өөрийн эрхгүй “Энэ чинь ямар гээчийн сүм бэ?” гэсэн бодол төржээ.

Энэ нь Доуд гүн сэтгэгдэл төрүүлж, тэр Сүмийн тухай болон баяр баяслаар дүүрэн хүмүүсийнх нь талаар илүү сайн судлахаар шийдэв. Харин түүнийг судалж эхэлмэгц түүнд сайн сайхныг хүсдэг байсан гэр бүлийнхэн болоод найз нөхөд нь хийж буй бүхий л үйлдлийг нь буруушаах болжээ. Тэд Сүмийн талаар муу муухай зүйлс хэлж, түүнийг болиулахын тулд бүхий л аргаа хэрэглэв.

Гэвч Доу гэрчлэл хүлээж авсан аж.

Тэр итгэлтэй байж, амьдралыг нь баяр баясгалангаар дүүргэх болсон сайн мэдээг хайрлах болов. Тиймээс тэр баптисм хүртсэн байна.

Үүний дараа тэр судлах, залбирахад өөрийн биеийг зориулжээ. Тэр мацаг барьж, Ариун Сүнсний нөлөөг амьдралдаа эрэлхийлэх болов. Үүний үр дүнд Доугийн гэрчлэл, итгэл хүчирхэгжин, гүнзгийрчээ. Эцэст нь тэр Их Эзэний төлөө бүрэн цагийн номлолд үйлчлэхээр шийдсэн байна.

Номлолоос эргэж ирснийхээ дараа тэр хэдэн жилийн өмнө өөрт нь баптисм хүртээж байсан эргэж

ирсэн номлогчтойгоо болзож, улмаар гэрлэжээ. Тэд дараа нь Өмнөд Африкийн Иоханнесбургийн ариун сүмд лацдан холбуулсан байна.

Доу Каку анх Есүс Христийн сайн мэдээний баяр баясгаланг мэдэрснээс хойш олон жил улиран өнгөрсөн. Тэр хутагаанд амьдрал нь үргэлж шулуун дардан байсангүй. Тэр, хоёрын хоёр хүүхдээ алдсан гээд маш их зовлон шаналлыг туулсан бөгөөд өнөөдөр ч гэсэн эдгээр үйл явдлаас үүссэн гуниг харууслын ул мөрийг мэдэрсээр байдаг.

Гэхдээ тэрээр нөхөр Антонигийн хамт бие биендээ төдийгүй бүхий л зүрх сэтгэлээрээ хайрладаг Тэнгэрлэг Эцэгтэйгээ ойр дотно байхыг хичээсэн.

Өнөөдөр, баптисм хүртсэнээсээ хойш 30 жилийн дараа Каку эгч өөр нэгэн бүрэн цагийн номлолыг хийж дуусгажээ. Энэ удаад тэр нөхрийгөө Нигерт номлолын ерөнхийлөгчөөр ажиллахад нь хамт үйлчилсэн юм.

Каку эгчийг мэддэг хүмүүс түүнийг онцгой нэгэн гэж хэлдэг бөгөөд царайнд нь үргэлж гэрэл гийж байдаг. Түүнтэй хамт байхад аз жаргалыг мэдрэхгүй байхын аргагүй.

“Аврагч намайг өөрийнхөө охин мөн найз гэж хардаг гэдгийг би мэднэ” гэсэн тодорхой гэрчлэл түүнд бий (Мозая 5:7; Ифер 3:14-ийг үзнэ үү). “Түүнчлэн би зөвхөн үг хэлээрээ биш мөн үйл хөдлөлөөрөө Түүний найз байхыг үнэхээр их хичээж, суралцаж байна” хэмээн тэр хэлсэн юм.

Бид бол шавь

Каку эгчийн түүх бусад олон хүний түүхтэй адил. Түүнд үнэнийг мэдэх хүсэл байсан бөгөөд тэр сүнслэг гэрлийг олж авах төлөөсийг төлж, Бурханыг болон хөршөө хайрладаг гэдгээ харуулж, замдаа зовлон бэрхшээл, уй гашууг амссан.

Ямар ч эсэргүүцэл, зовлон бэрхшээлтэй тулгарсан бай, тэр итгэлтэй байж урагшилсаар байсан. Хамгийн чухал нь тэр энэ явцад баяр баясгалантай байж чадсан. Тэр зовлон бэрхшээлийг даван туулахын зэрэгцээ зовж зүдэрсэн ч гэсэн өөдлөн дэвжих арга замыг олсон байлаа.

Түүний түүх миний мөн таны түүхтэй адил.

Бидний аялал шулуун дардан эсвэл зовлон бэрхшээлгүй байх нь ховор.

Бидний хүн нэг бүрд сэтгэлийн зовлон, урам хугалах үйл явдал, уй гашуу тохиолддог.

Тэр ч бүү хэл сэтгэл гонсойн, цочирдож ч болох юм.

Гэхдээ шавь хүний амьдралаар амьдарч, итгэлтэй байж мөн итгэл дүүрэн урагшилж, Бурханд найдан, зарлигуудыг нь сахиж¹, өдөр тутам, цаг мөч бүрд сайн мэдээний дагуу амьдарч, эргэн тойрныхондоо Христийнхтэй адилаар, өчүүхэн ч гэсэн сайн үйл хийж үйлчилдэг хүмүүсийн зөв үйлс том өөрчлөлт авчирдаг.

Тэд илүү эелдэг, илүү өршөөнгүй мөн энэрэнгүй байснаар ивээл энэрэл хүртэх болно.² Хайр, халамжийн сайн үйлийг бага багаар хийн, энэ дэлхийг илүү сайн сайхан болгож, Есүс Христийн шавийн адислагдсан, сэтгэл хангалуун, амар амгалан амьдралаар амьдрахыг хичээдэг хүмүүс эцэстээ баяр баясгаланг олох болно.

Тэд “энэ бол хүмүүний үрсийн зүрхэнд хааяагүй түгэх Бурханы хайр . . . хамгийн ихээр хүслийг татагч буюу . . . мөн бодгальд хамгийн их баясгалант болой”³ гэдгийг мэдэх болно.

ЭШЛЭЛҮҮД

1. Мозая 4:6-г үзнэ үү.
2. Матай 5:7-г үзнэ үү.
3. 1 Нифай 11:22–23.

ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Угдорф шавь байх зам хүнд хэцүү ч “Есүс Христийн амгалан дөлгөөн дагалдагчид эцэст нь баяр баяслыг олох болно” гэдгийг бидэнд заасан. Тэр Христийн жинхэнэ шавь амьдралын зовлон бэрхшээл дундаас амар амгалан, баяр баясгаланг хэрхэн олж

болдгийг харуулахын тулд Доугийн түүхийг ярьсан шиг та ч бас яагаад Христийг дагахыг сонгосноо мөн Тэр хэрхэн таныг хүчирхэгжүүлсэн тухай өөрийн амьдралын түүхээс хуваалцахыг бодоорой. Сүнсээр өдөөгдөх үедээ хувийн түүхээсээ хуваалцах нь зааж буй хүмүүсээ хүчирхэгжүүлэхэд тусалдаг.

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Есүс Христийн шавь байхын баяр баясгалан

Та нарт азгүй өдөр тохиолдож байсан уу? Та нарт сэтгэлээ сэргээхийн тулд юу хийсэн бэ? Ерөнхийлөгч Угдорф “Бид бүгдэд сэтгэлийн шарх, сэтгэл гутрал, гуниг харуусал байдаг. Бид бүр айж балмагдаж ч магадгүй бөгөөд зарим үед гайхан бахдаж ч болно” гэдгийг мэддэг.

Тэр “шавь хүний амьдралаар амьдарч, итгэлтэй хэвээр үлдэн, итгэл дүүрэн урагшлахыг” санал болгосон. Бид итгэлээр урагшлах үед Бурханд итгэж найдан, зарлигуудыг нь дагаж, бусдад үйлчлэх боломжтой болдог бөгөөд энэ бүхнийг баяр баясгалантай хийдэг билээ! Ерөнхийлөгч Угдорфын хэлснээр “Шавь хүний амьдралаар амьдардаг хүмүүсийн хийсэн өчүүхэн ч гэсэн сайн үйл том өөрчлөлт авчирдаг”.

Шавь хүний амьдралаар амьдрах арга замуудыг жагсаан бичихийг бод. Жишээлбэл, “эцэг эхдээ оройн хоол хийхэд нь туслах” зэрэг үйлчлэл хийх санаа эсвэл “ах, эгч, дүүдээ илүү тэвчээртэй хандахын төлөө залбирах” гэх мэт зарлигуудыг дагах санааг тус тус бичиж болно. Дараа нь сэтгэлээр унах юм уу цөхөрсөн үедээ жагсаалтаа гаргаж ирээд, аль нэг санааг сонгон авч, хэрэгжүүлж үзээрэй!

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Амьдралын аз жаргалтай болон гунигт цаг үе

Зарим өдөр тийм ч сайхан байдаггүй ч энэ нь байдаг л зүйл. Ийм үед Есүс та нарт тусалж чадна.

Хөмсгөө зангидсан царай зур. Та нарыг гунигтай байхад Есүс хэрхэн тусалж чадах вэ? Харин одоо инээмсэглэсэн царай зур. Есүс та нарыг баяртай байхад хэрхэн тусалж чадах вэ?



Өргөл болгосон амьдралаар амьдрах нь

Энэ материалыг залбирч судлаад, юуг хуваалцахаа мэдэхийн тулд сунслэг өдөөлт эрэлхийл. Халамжийн нийгэмлэгийн зорилгыг ойлгох нь Бурханы охидыг мөнх амьдралын адислалуудад хэрхэн бэлтгэх вэ?

Итгэл, гэр бүл, халамж

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон: “Өргөл болгох гэдэг нь аливаа зүйлийг нандин болгож мөн ариун зорилгод зориулахын тулд онцгойлон адислахыг хэлнэ. Энэ амьдралын жинхэнэ амжилт нь биднийг Бурханы зорилгод цаг зав болон сонголтоо зориулах үед л ирдэг”¹ хэмээн хэлсэн.

Харин Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004) “Бид өргөл болгосон амьдрал гэдгийг тэнгэрлэгээр удирдуулагдсан үед зүгээр л материаллаг эд зүйлээ өргөл болгох гэж ойлгох гээд байдаг. Гэвч жинхэнэ өргөл бол хүн өөрийгөө Бурханд зориулах явдал мөн”² гэж хэлжээ.

Бид Бурханы зорилгуудад өөрсдийгөө зориулах аваас Есүс Христэд болон Түүний Цагаатгалд итгэх итгэл маань нэмэгдэх болно.

Бид өргөл болгосон амьдралаар амьдарснаар тэдгээр үйлдлээрээ ариун болгогдох болно.

Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн нэгдүгээр зөвлөх Кэрол М.Стэфэнс: “Ахлагч Роберт Д.Хэйлс ‘Бид гэрээ байгуулж, түүнийгээ сахиснаар дэлхийгээс гарч Бурханы хаант улс руу ордог’ гэж заасан.

Бид өөрчлөгдсөн. Бид өөр харагддаг төдийгүй өөрөөр үйлддэг. Бид Бурхантай гэрээ байгуулж, Түүний охид болсон учраас бидний сонсож, уншиж, хэлж байгаа зүйлс хүртэл өөр болдог”³ гэжээ.

Өргөл болгох нь “тэдгээр өдрүүдийн дараа Израилийн гэртэй [Бурханы] байгуулах гэрээ юм гэж Эзэн тунхаглаж байна. Би Өөрийн хуулийг тэдний дотор хийж, зүрхэн дээр нь Би түүнийг бичнэ. Би тэдний Бурхан, тэд Миний ард түмэн болно”

(Иеремиа 31:33). Өргөл болгосон амьдралаар амьдрах нь Бурханы бидэнд зориулсан төлөвлөгөөтэй нийцдэг.

Нэмэлт судрууд

1 Тесалоник 1:3; Сургаал ба Гэрээ 105:5; reliefsociety.lds.org

ЭШЛЭЛҮҮД

1. Д.Тодд Кристоффэрсон, “Өргөл болгосон амьдралын тухай бодол эргэцүүлэл,” 2010 оны 11-р сарын Ерөнхий чуулган, 17.
2. Нийл А.Максвэлл, “Consecrate Thy Performance,” *Лиакхона*, 2002 оны 7-р сар, 39.
3. Кэрол М.Стэфэнс, “Үүрэг хариуцлагаа үлэмж сэргэг байх нь,” 2012 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 141.

Үүнийг эргэцүүлэн бод

Амьдралаа Их Эзэнд өргөл болгох нь Түүнтэй илүү адил болоход хэрхэн тусалдаг вэ?